БАТЛАВ
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Т.АУБАКИР

2026 оны 07 сарын 03 өдөр

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.АМАРСАЙХАН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан.

Монгол Улс 2009 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, дотоодын хууль тогтоомжийг тус конвенцын зарчим, хүний эрхийн загварт нийцүүлэн боловсронгуй болгох үүрэг хүлээсэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос 2023 онд Монгол Улсад өгсөн зөвлөмжид үндэсний хууль тогтоомж, бодлогыг хянан үзэж, хөгжлийн бэрхшээлийн хүний эрхийн загварыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгарч буй эрх зүйн, орчны болон хандлагын саадыг бууруулах, бие даан амьдрах, нийгэмд бүрэн хамрагдахад шаардлагатай дэмжлэг, туслалцааны зохицуулалтыг "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц"-д нийцүүлэх шаардлагыг дурдсан.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.23-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна.” гэж тусгасан.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан болно.

1.2. Практик шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд батлан хэрэгжүүлснээс хойш нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч уг хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бодитой хэрэгжүүлэх механизм, салбар хоорондын уялдаа, байгууллагын чиг үүрэг, хяналт-хариуцлагын зохицуулалт хангалттай тусгагдаагүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр хуулийн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй, төрийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч, иргэний нийгмийн байгууллагууд нэгдмэл ойлголт, арга зүйтэй болоогүй, хүний нөөц, мэргэжлийн чадавх болон салбар хоорондын хамтын ажиллагаа сул байгааг тогтоосон.

Мөн оюуны бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог хангах, тэд өөрт нь хамааралтай асуудлаар хэрхэн шийдвэр гаргах, хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч, хөгжих эрхийг хангахад боловсролын байгууллагын хүртээмж, сургалтын чанар, заах арга зүй, мэргэшсэн багш, мэргэжилтний асуудлыг зохицуулаагүй, хөгжлийн бэрхшээлийг өвчний оношоор тогтоож байгаа нь олон улсын жишигт нийцээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхийг хангахад үзүүлэх дэмжлэгийн төрөл хязгаарлагдмал зэрэг олон асуудал тулгамдаж байгааг дээрх үнэлгээгээр тогтоожээ.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад 106.2 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.1 хувь бөгөөд үүнээс 11.1 мянга нь харааны, 7.1 мянга нь сонсголын, 18.1 мянга нь хөдөлгөөний, 21.2 мянга нь сэтгэцийн, 3.6 мянга нь хэл ярианы, 7.7 мянга нь хавсарсан, 37.4 мянга нь бусад хэлбэрийн бэрхшээлтэй байна.

"Статистик мэдээллээр, улсын хэмжээнд хөдөлмөрийн насны (15-64 нас) 89.6 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 16.2 мянга нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Ийнхүү тэдгээрийн 80 орчим хувь нь хөдөлмөрийн зах зээлд хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд энэ нь ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, ур чадварт нь нийцсэн ажлын байр олдохгүй, ажил олгогчдын зүгээс шаардлагатай ажлын байрны тохируулгыг бүрдүүлээгүй, орчны хүртээмжийн саад зэрэг олон шалтгаан нөлөөлж байна. Түүнчлэн асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ асарч, хуулийн дагуу асаргааны тэтгэмж авч буй 34.0 мянга орчим иргэн байдаг. Эдгээр иргэдийн тодорхой хэсгийн хөдөлмөр эрхлэх боломж давхар хязгаарлагддаг нь тухайн өрхүүдийн орлого тасалдах, амьжиргааны түвшин буурах үндсэн шалтгаан болж байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 4 хүн тутмын 1 нь боловсролгүй байна. Монгол Улсад 2025 оны байдлаар 0-18 насны 15.2 мянган хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байгаагаас сургуулийн өмнөх боловсролд 2175, ерөнхий боловсролын сургуульд 6735 хүүхэд хамрагдсан нь нийт хүүхдийн 58.6 хувь байна. Шатлал ахих тусам хамрагдалт буурч, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 633, дээд боловсролын байгууллагад 347, насан туршийн суралцахуйд 392, дэмжих үйлчилгээнд 125 хөгжлийн бэрхшээлтэй хүн хамрагдсан байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт, сургууль завсардалт, боловсролын байгууллагын барилга байгууламжийн хүртээмж, сургалтын хэрэглэгдэхүүн, тохируулга, дээд боловсрол эзэмших боломж зэрэг

асуудлыг эрх зүйн хувьд илүү тодорхой, хэрэгжихүйц байдлаар зохицуулах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд давхардал үүсгэсэн 2, хуулийн хийдэл үүсгэсэн 28, зөрчилдөж буй 21 заалт байгааг үнэлгээгээр тогтоосон. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насыг 0-18 нас гэж тогтоосон, "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэсэн нэр томьёо хэрэглэсэн бол Нийгмийн халамжийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насыг 16 хүртэл гэж тогтоон, "хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж томьёолсон нь хамрах хүрээний зөрчил үүсгэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний үндсэн эрхийг баталгаажуулж, түүнийг хангахад чиглэсэн нарийвчилсан зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэх байдлаар давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай юм.

Хуулийн нэр томьёог Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт 2023 онд өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх, Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д тулгуурлан хөгжлийн бэрхшээлийг тогтоох замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлага үүссэн.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан бүтэц, тогтолцоог оновчтой болгох, эрх хэмжээ, чиг үүргийг нарийвчлах, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих шаардлага, шалгуурыг тодорхойлох, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулах, үр дүнг хянах харилцааг тодорхой болгох хэрэгцээ үүссэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах асуудал нь зөвхөн нийгмийн хамгааллын салбараар хязгаарлагдахгүй боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, зам тээвэр, барилга хот байгуулалт, соёл спорт зэрэг төрийн бүх шатны байгууллагуудыг хамарсан салбар дундын шинжтэй тул уялдуулан зохицуулах нэгдсэн механизм нэн үгүйлэгдэж байна. Өнөөгийн тогтолцоонд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбар дундын бодлогыг зангидаж, шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавьж хариуцлага тооцох бодит эрх мэдэл, эрх зүйн чадамж сул байгаагаас шалтгаалан салбар хоорондын уялдаа холбоо алдагдаж, хуулийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байсаар ирлээ.

Иймд салбар дундын бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд бодитой уялдуулан зохицуулах, конвенц болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд нэгдсэн удирдлагаар хяналт тавих, тогтоол, дүрэм, журам батлах, салбар болон дэд зөвлөлүүдэд албан даалгавар өгч биелэлтийг дүгнэх зэрэг эрх үүргийг нэмэгдүүлж, Үндэсний зөвлөлийг өргөн бүрэн эрхтэй болгон өргөжүүлэх практик шаардлага үүсээд байна.

Мөн Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн хүний нөөц хомс байгаа тул тухайн салбарын ажилтныг мэргэшүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлж тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байна.

Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, барилга, хот байгуулалт, нийтийн үйлчилгээ зэрэг салбарын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдөх тохиолдол гарч байгаа боловч эрх зөрчигдсөн үед гомдол, нэхэмжлэл гаргах, зөрчлийг арилгуулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий тухай хуульд хангалтгүй байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрт шаардлагатай үйлчилгээ, тусламж, дэмжлэгийг цаг алдалгүй авах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааг тогтвортой дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зардлыг холбогдох байгууллагын төсөвт тодорхой тусгах, төсвийн жилийн мөчлөгөөс үл хамааран үйлчилгээг тасралтгүй хүргэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн бүтэц, уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Энэ хуулийн төслийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөг бүрэн, тэгш эдлүүлэх, нийгмийн харилцаанд үр дүнтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрхийг хангахад баримтлах зарчим, үзүүлэх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, бүртгэх, төр, иргэн, хуулийн этгээдийн дэмжлэг, оролцоо, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/хуулийн зорилтыг тодорхойлж, одоогийн хуульд заасан зарим нэр томьёоны найруулгыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон олон улсын чиг хандлагад нийцүүлэн өөрчилж, өргөжүүлэх, хуулийн үйлчлэх хүрээ, зарчмыг тодорхойлно;

2/хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх, үл ялгаварлан гадуурхах, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй холбоотой харилцааг тусгана;

3/хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг Боловсролын ерөнхий хууль болон холбогдох бусад хуультай уялдуулан, бүх шатны боловсролын байгууллагад суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалт, дэмжих үйлчилгээ, шаардлагатай тохируулга, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, мэдээлэл, технологийн хүртээмж, тэтгэлэг болон бусад дэмжлэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоно;

4/хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх эрхийг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хуультай уялдуулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, ажлын байрны шаардлагатай тохируулга, дадлагажуулагчийн үйлчилгээ, зорилтот ажлын байр, ажил олгогчийн үүрэг, квотын хэрэгжилт, дэд сангийн дэмжлэгийн зохицуулалтыг тусгана;

5/хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуультай уялдуулан, хүртээмжтэй үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зохицуулна;

6/хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн сэргээх, бие даан амьдрах эрхийг баталгаажуулж, сэргээн засах болон амьдралын чадварт бэлтгэх зорилгоор туслах хэрэглэгдэхүүн, хувийн туслах, дэмжих бүлэг, түр байрлуулах, дохионы хэлний хэлмэрч, хөтөч үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаас гадна, байгууллагад суурилсан тусгаарлалтын хэлбэрийг үе шаттай бууруулах зохицуулалтыг тусгана;

7/хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийг холбогдох хуультай уялдуулан, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, асаргаа, нийтийн тээвэр, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмж, мэдээлэл, зөвлөгөө, гэр бүлийн гишүүнд үзүүлэх дэмжлэгийн зохицуулалтыг нарийвчилна;

8/хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрхийн хүрээнд орон байр, онцгой байдлын үеийн хамгаалалт, хууль зүйн туслалцаа, эрх зүйн чадамж, дэмжлэгтэй шийдвэр гаргах, улс төрийн оролцоо, хувийн мэдээлэл хамгаалалт, биеийн тамир, спорт, соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна;

9/хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, бүртгэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн нэгдсэн сан бий болгох, мэдээлэл бүрдүүлэх, солилцоо, үйл ажиллагаа шинэчилнэ;

10/хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний зөвлөл, дэд болон салбар зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, хуулийн этгээдийн чиг үүргийг тодорхойлно;

11/хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагад тавих шаардлага, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх, үйлчилгээний үр дүн, хяналт, хариуцлагын зохицуулалтыг тусгана;

12/хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний хууль ёсны төлөөлөгч эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдол, хүсэлт, нэхэмжлэл гаргах, зөрчлийг арилгуулах, гэм хор, хохирлыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомж зөрчигчид хариуцлага хүлээлгэх, хууль хүчин төгөлдөр болох болон шилжилтийн зохицуулалтыг тусгана.

Гурав. хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр нөлөө бий болно. Үүнд:

–Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой төрийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хуулийн этгээд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын чиг үүрэг, хариуцлага тодорхой болж, эрхийг бодитой хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, чадвар, сонголтод нийцсэн үйлчилгээ, дэмжлэгийн төрөл, хүрээ тодорхой болж, халамжид төвлөрсөн хандлагаас оролцоо, хөдөлмөр эрхлэлт, бие даан амьдрах боломжийг дэмжих чиглэлд шилжинэ.

-Боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, сэргээн засах, нийгмийн хамгаалал, хүртээмжийн зохицуулалт салбарын хуультай уялдаж, давхардал, хийдэл, зөрчил буурна.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтийг хянах, гомдол, нэхэмжлэл гаргах, зөрчигдсөн эрхийг сэргээх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин сайжирна.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдээллийн нэгдсэн сан, үнэлгээний аргачлал, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо сайжирч, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах нөхцөл бүрдэнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх нийгмийн ойлголт, хандлага сайжирч, ялгаварлан гадуурхалт, орчны болон хандлагын саадыг бууруулахад дэмжлэг болно.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдуулсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

20…. оны …. дугаар сарын ...ны өдөр

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хүний эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш, бүрэн эдлэх, нийгмийн харилцаанд үр дүнтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, бүртгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, түүний эрхийг хангах, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн оролцоо, эрх, үүрэг, хариуцлага, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“бие даан амьдрах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай дэмжлэг, үйлчилгээний тусламжтайгаар амьдрах орчноо мэдээлэлд үндэслэн өөрөө сонгож, шийдвэр гаргаж амьдрахыг;

4.1.2.“бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын үйлдэл, үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадамжийн түвшнийг тодорхойлж, тулгамдсан асуудал, хэрэгцээг эрэмбэлэн тогтоох үйл ажиллагааг;

4.1.3.“брайль бичиг” гэж харааны бэрхшээлтэй хүн хуруугаар тэмтэрч унших зориулалттай, товгор цэгэн тэмдэгтээс бүрдсэн бичгийн тогтолцоог;

4.1.4.“туслах хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд амьдралын өдөр тутмын үйлдлээ гүйцэтгэх, нийгмийн харилцаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, алдагдсан үйл ажиллагааг нь орлох, нөхөх, үйл ажиллагааны чадварыг нь сайжруулах, хадгалах, эсхүл эрүүл мэнд нь дордохоос сэргийлэх зорилготой хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, программ хангамж зэргийг;

4.1.5.“урт хугацааны сэргээн засах үйлчилгээ” гэж хүний бие бялдар, сэтгэл зүй, мэдрэхүй, танин мэдэхүй болон нийгмийн оролцооны алдагдсан, эсхүл буурсан чадварыг сэргээх, хадгалах, сайжруулах зорилгоор урт хугацаанд тасралтгүй үзүүлэх эрүүл мэнд, нийгэм, боловсрол болон дэмжих цогц үйлчилгээг;

4.1.6.“урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.7.“хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.8.“хөгжлийн бэрхшээл” гэж хүний бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн урт хугацааны алдагдал нь нийгмийн хандлага, орчны болон бусад саад бэрхшээлтэй харилцан үйлчилснээр түүний нийгмийн амьдралд бусадтай адил тэгш, бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломжийг хязгаарлаж буй, нийгэм, орчны нөхцөлөөс хамааран өөрчлөгддөг ойлголтыг;

4.1.9.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн урт хугацааны алдагдал нь хандлага, орчны болон бусад саад бэрхшээлтэй харилцан үйлчилснээр нийгмийн амьдралд бусадтай адил тэгш, бүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.10.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүний улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд хүний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, шаардлагатай тохируулгаар хангагдах, бие даан амьдрах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.11.“хөтөч” гэж хөгжлийн бэрхшээлтэй болон бусад дэмжлэг шаардлагатай хүнийг аюулгүй зорчуулах, орчинд чиглүүлэх, мэдээллээр хангах зорилгоор тодорхой хугацаанд замчлан дагалдах хүнийг;

4.1.12.“хувийн туслах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын өдөр тутмын үйлдэлд болон бие даан амьдрахад туслах үйлчилгээ үзүүлдэг хүнийг;

4.1.13.“шаардлагатай тохируулга” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэх боломжийг хангах зорилгоор тухайн хүний хэрэгцээнд нийцүүлэн өөрчилсөн, эсхүл бүрдүүлсэн орчин, нөхцөл, хүний нөөц, үйлчилгээний төрөл, хэлбэр, хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийг.

5 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах бодлого, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн алдагдал, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж, илэрсэн даруй эрт оролцоог дэмжсэн цогц үйлчилгээгээр хангах;

5.1.2.аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.3.сонголт хийх эрхийг хангах, онцлог, ялгаатай, хараат бус, бие даасан байдлыг хүндэтгэх;

5.1.4.хөгжих, нийгмийн бүхий л харилцаанд бүрэн, үр дүнтэй оролцох, тэгш хамрагдах боломжийг хангах;

5.1.5.саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх, тэгш боломж олгох;

5.1.6.бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний төлөөллийн оролцоог хангах;

5.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсан хөгжих чадавхыг хүндэтгэж, өөрийн онцлогоо хадгалах эрхийг нь хүлээн зөвшөөрөх;

5.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзах;

5.1.9.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын онцлог хэрэгцээг харгалзах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ

6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, үндэсний баялгаас адил хүртэх эрхтэй.

6.2.Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд хүн, хуулийн этгээдийн дараах шууд ба шууд бус үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;

6.3.2.өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тэгш хамран суралцахад шаардагдах тохируулга бүхий орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, үл хайхрах, дарамт, шахалт үзүүлэх;

6.3.3.хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг оролцуулахаас татгалзах, зайлсхийх;

6.3.5.нийтийн барилга байгууламж, авто зам, замын байгууламжид хүрэх, түүнийг ашиглах, нийтийн тээврийн хэрэгслээр саадгүй зорчих хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;

6.3.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох улс төрийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх;

6.3.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гутаан доромжлох, нэр төр, алдар хүнд, эрхэм чанарт халдах.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд хүн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах, зайлсхийх;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.хуулийн этгээд ажилтныг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам хэрэгжүүлэх, удирдлагын арга барилыг ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн, шаардлагатай тохируулга бүхий ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох.

6.5.Гэр бүл, олон нийтийн орчин дахь дараах үйлдлийг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүнийг гадуурхах;

6.5.2.хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтэд буруу, ташаа ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх;

6.5.3.хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.4.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух, түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх, чадавхжуулах үйлчилгээнд хамруулахаас татгалзах, зайлсхийх;

6.5.5.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүний үр хүүхдээ асран хүмүүжүүлэх эрхийг хуульд зааснаас бусад үндэслэлээр хязгаарлах;

6.5.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх болон хуульд заасан бусад эрхийг хязгаарлах;

6.5.7.хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар гэр бүлтэй болох, гэрлэх, хөрөнгө өвлөх эрхийг хязгаарлах;

6.5.8.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрх, нөхөн үржихүйн асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхийг хязгаарлах, түүнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр үргүйжүүлэх, үр хөндүүлэх.

6.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг бодитой хангах, онцлог хэрэгцээнд нь нийцүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

7 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

7.1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн алдагдал, хөгжлийн хоцрогдол илэрсэн даруйд хүн, түүний гэр бүлийг мэдээ, мэдээллээр хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээнд холбон зуучлах;

7.1.2.хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, шаардлагатай тохируулгын талаар сургалт, сурталчилгааг өөрийн зардлаар жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;

Тайлбар: “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ хангамж, орчин болон үйлчилгээний хэв маяг, архитектурын шийдлийг хэлнэ;

7.1.3.хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт, мэдлэгийг түгээх, энэ чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн хөтөлбөрийг олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй,

бусад хэвлэл мэдээллийн байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд нийтийн хүртээл болгох;

7.1.4.бүх шатны төрийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

7.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.1.1-д, бүх шатны төрийн байгууллага энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

7.3.Бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн алдагдал, хөгжлийн хоцрогдлыг илрүүлсэн эрүүл мэндийн байгууллага тухайн хүн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8.2-т заасан нөхцөл, зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхийг танилцуулж, мөн хуулийн 8.3-т заасан хэлбэрээр зөвшөөрөл авсан бол түүнээс хойш 24 цагийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

7.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.3-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 7.1.1-д заасан үйлчилгээг өөрөө, эсхүл энэ хуулийн 7.2-т заасны дагуу гэрээлэн гүйцэтгүүлж үзүүлнэ.

7.5.Энэ хуулийн 7.1.1-д заасан үйлчилгээний санхүүжилтийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

7.6.Энэ хуулийн 7.3-т заасны дагуу мэдэгдэх, 7.2-т заасны дагуу гэрээлэн гүйцэтгэгчид шилжүүлэх мэдээлэл нь тухайн хүний овог, нэр, холбоо барих мэдээлэл болон үйлчилгээнд холбон зуучлахад зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн мэдээллээр хязгаарлагдах бөгөөд мэдээлэл хүлээн авсан байгууллага, гэрээлэн гүйцэтгэгч уг мэдээллийг энэ хуулийн 7.1.1-д зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

7.7.Хүн, түүний хууль ёсны төлөөлөгч энэ хуулийн 7.3-т заасан зөвшөөрөл өгөхөөс татгалзсан, эсхүл зөвшөөрлөө цуцалсан нь энэ хууль болон бусад хуульд заасан тусламж, үйлчилгээ авах эрхийг нь хязгаарлахгүй. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллага энэ хуулийн 7.1.1-д заасан үйлчилгээг хаанаас, хэрхэн авах талаарх мэдээллийг тухайн хүнд өгнө.

8 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний орчны хүртээмжийг сайжруулах

8.1.Барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, бүх төрлийн үйлчилгээ, мэдээллийн технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй, түгээмэл загвартай байна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан саадгүй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

9 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх дэмжих үйлчилгээ, санхүүжилт

9.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Боловсролын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу сурч боловсрох эрхтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролд бүрэн хамруулна.

9.2.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид дараах дэмжих үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлнэ:

9.2.1.суралцагчийн хэл яриа, танин мэдэхүй, харилцаа, амьдрах ухаан, бие бялдрыг хөгжүүлэх сургалт, нэмэлт хичээл, давтлага өгөх;

9.2.2.брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох;

9.2.3.боловсролын сургалтын байгууллагын орчинд хувийн хөдөлгөөнт байдлыг хангах, өдөр тутмын үйлдлээ гүйцэтгэхэд нь туслах;

9.2.4.амраах, тайвшруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;

9.2.5.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийн сургалт, хөгжлийн чиглэлээр зөвлөн туслах.

9.3.Бүх шатны боловсролын байгууллага нь энэ хуулийн 9.2.4-т заасан үйлчилгээг үзүүлэх, суралцагч онцлог хэрэгцээндээ нийцүүлэн тайван орчинд амрах, дэмжлэг авах өрөөтэй байна.

9.4.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоодын болон гадаадын мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургуульд суралцах эрхтэй болсон суралцагчид Боловсролын зээлийн сангаас дараах дэмжлэгийг үзүүлнэ:

9.4.1.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөр, дотоодод суралцаж байгаа бол дотуур байрны зардал, гадаадад суралцаж байгаа бол амьжиргааны зардал;

9.4.2.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн болох хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гадаад улс, эсхүл оршин суугаа газраас өөр хот, аймаг, суманд суралцах бол сургуульдаа ирэх, буцах унааны зардлыг хичээлийн жилд нэг удаа;

9.4.3.хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр;

9.4.4.Боловсролын ерөнхий хуулийн 25.1.3-т заасан жагсаалтаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх мэргэжлээр суралцах суралцагчид тэтгэлэг.

9.5.Энэ хуулийн 9.4.4-т заасан мэргэжлээр элсэлтийн шалгалтад тэнцэж, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах эрхтэй болсон, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн болох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сургалтын төлбөрийг Боловсролын зээлийн сан бүрэн хариуцна. Энэ хуулийн 9.4.1, 9.4.3, 9.4.4-т болон энэ хэсэгт заасан сургалтын төлбөрийн дэмжлэгийг нэг суралцагчид давхардуулан олгохгүй.

9.6.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн энэ хуулийн 9.2-т заасан дэмжих үйлчилгээний хэрэгцээг үнэлэх аргачлал, үйлчилгээний хөтөлбөр, үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага, гүйцэтгэлийг тайлагнах журмыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/-ийн саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.7.Энэ хуулийн 9.2-т заасан дэмжих үйлчилгээ, 11.6-д заасан шаардлагатай тохируулгын зардлыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежид Боловсролын ерөнхий хуулийн 38.2, 38.5.1-д заасан хувьсах зардлаар, төрийн болон орон нутгийн өмчийн бусад боловсролын сургалтын

байгууллагад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүжүүлнэ.

9.8.Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг Боловсролын ерөнхий хуулийн 38.5.6-д заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10 дугаар зүйл.Монгол дохионы хэл, брайль бичиг

10.1.Монгол дохионы хэл бол сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний албан ёсны хэл мөн.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан дохионы хэлийг ашиглах, эзэмших, хөгжүүлэхтэй холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

10.3.Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага батална.

11 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үйлчилгээ үзүүлэх боловсролын байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

11.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших эрхийг хангах, хөгжлийг дэмжих чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.1.1.хүүхдийн сурлагын хоцрогдлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, хяналт тавих;

11.1.2.боловсролын сургалтын байгууллагын барилга, анги танхим, сургалтын орчны хүртээмжийг хангах, сайжруулах;

11.1.3.боловсролын байгууллагын багш, ажилтанд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах арга зүйг эзэмшүүлэх;

11.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн шаардлагатай тохируулгатай, хүртээмжтэй орчинд элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, нэмэлт цаг олгох;

11.1.5.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь нийцэх ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

11.1.6.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3-т заасан төлөвлөгөөний хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц дэвшлийн талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн санд тогтмол байршуулах;

11.1.7.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дараагийн шатны боловсролын байгууллагад дэвшин суралцах бэлтгэл хангах зорилгоор шилжилтийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх;

11.1.8.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.5-д заасан сургуулийг суралцагчид үйлчлэх автобусаар хангах;

11.1.9.сургалтын материал, сурах бичгийг брайль хэлбэрээр бэлтгэх боломжийг бүрдүүлэх;

11.1.10.багш, ажилтныг брайль бичгийн мэдлэгтэй болгох сургалтыг дэмжих;

11.1.11.дэлгэц уншигч, брайль төхөөрөмж зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэхийг дэмжих;

11.1.12.харааны бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах дэд бүтцийг хөгжүүлэх;

11.1.13.дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг 2 багц цагаар тооцох;

11.1.14.хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, хэлмэрч, орчуулагч, сэтгэл зүйч, арга зүйч, протез, ортезийн техникч зэрэг нэн шаардлагатай мэргэжлийг Боловсролын ерөнхий хуулийн 25.1.3-т заасан жагсаалтад тусгаж, энэ хуулийн 9.4.4-т заасны дагуу дотоод, гадаадад сургаж бэлтгэх.

11.2.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид чанартай боловсролыг хүртээмжтэй олгож, амьдрах ухаан, ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.Боловсролын ерөнхий хуулийн 8.3-т заасан төлөвлөгөөний хэрэгжилт, суралцагчийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц дэвшлийг байгууллагын гүйцэтгэх удирдлага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой үнэлж, дүгнэлтийг боловсролын асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон энэ хуулийн 29.2.1-д заасан зөвлөлд жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлэх;

11.2.2.эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад бүрэн хамрагдаж чадахгүй байгаа, эсхүл сурлагын хоцрогдолтой хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид туслах багш тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн явуулын үйлчилгээ үзүүлэх;

11.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрэн болон бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн бол цаашид суралцах, эсхүл хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх, ажил олгогчдод танилцуулах, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах;

11.2.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оршин суугаа газарт нь ойр байрлах өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд харьяалал харгалзахгүйгээр хамруулах;

11.2.5.байнгын асаргаа шаардлагатай, 18 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр Боловсролын ерөнхий хуулийн 34.2-т заасан зөвлөлийн шийдвэрээр 21 нас хүртэл ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулах;

11.2.6.танхимын сургалтаар боловсрол эзэмшихэд хүндрэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг танхимын бус сургалтад хамруулах.

11.3.Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасан боловсролын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид чанартай боловсролыг хүртээмжтэй олгох чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.3.1.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид энэ хуулийн 9.2-т заасан дэмжих үйлчилгээ үзүүлэх;

11.3.2.эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн болон барилга байгууламж, авто зам, замын байгууламж, мэдээллийн технологи, харилцаа холбоо, хүний нөөцийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, мэдлэг олгох агуулга тусгах;

11.3.3.элсэлтийн шалгалтад тэнцсэн хөгжлийн бэрхшээлтэй элсэгчийг тухайн хичээлийн жилд шинээр элсүүлэх суралцагчийн нийт тооны нэг хувиас доошгүй тоонд тэргүүн ээлжид элсүүлэх;

11.3.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг ажил олгогчдод танилцуулах, ажлын байранд зуучлах;

11.3.5.танхимын сургалтаар боловсрол эзэмшихэд хүндрэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг танхимын бус сургалтад хамруулах;

11.3.6.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хэрэгцээнд нь нийцүүлэн дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээ, хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлсэн сургалтын материал, туслах хэрэглэгдэхүүнээр хангах.

11.4.Энэ хуулийн 11.1.13-т заасан багц цаг тооцох журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.5.Цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны зардлыг Боловсролын ерөнхий хуулийн 38.5.4-т заасны дагуу санхүүжүүлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний, эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн цэцэрлэгт хамрагдаж байгаа нэг хүүхдийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлнэ.

11.6.Боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн шаардлагатай тохируулгын жагсаалт, түүнийг хэрэгжүүлэх журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

11.7.Бүх шатны боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид энэ хуулийн 11.6-д заасан шаардлагатай тохируулгыг хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЭРХ

12 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, түүний санхүүжилт

12.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу бусадтай адил тэгш хөдөлмөр эрхлэх эрхтэй.

12.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах үйлчилгээ үзүүлнэ:

12.2.1.ажлын байранд зуучлах;
12.2.2.хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээнд хамруулах;
12.2.3.санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
12.2.4.зорилтот ажлын байр бий болгох;
12.2.5.бизнес хөгжүүлэх, борлуулалтыг дэмжих;
12.2.6.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ.

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээ гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангахад чиглэсэн мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох, ажлын байранд зуучлах, дадлагажуулах, шаардлагатай тохируулга бүхий ажлын байр бий болгох, санхүүгийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах арга зүйгээр хангах зэрэг цогц арга хэмжээг ойлгоно.

12.3.Ажлын байранд нэмэлт дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа ажил олгогч ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээ авч болно.

12.4.Энэ хуулийн 12.3-т заасан ажлын байрны дадлагажуулагч нь арга зүйн сургалтад хамрагдсан эрх бүхий этгээд байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байранд дагалдуулан сургах, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хамт олны хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах хандлагыг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг үзүүлнэ.

12.5.Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх, ажиллуулах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

12.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дараах дэмжлэг үзүүлнэ:

12.6.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжлээрээ ажиллах, эсхүл өөртөө ажлын байр бий болгоход шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, шаардлагатай материал, хэрэгслийг худалдан авахад нь нэг удаагийн санхүүгийн дэмжлэг;

12.6.2.ажил олгогч мэргэжил эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсан, эсхүл сургалтад хамруулж ажлын байраар хангасан бол шаардлагатай тохируулга хийх, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь нэг удаагийн санхүүгийн дэмжлэг;

12.6.3.оюуны, сэтгэцийн болон хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах зорилтот ажлын байр бий болгох, ажлын байраа өргөтгөх, техник, технологи шинэчлэх, турших, нэвтрүүлэх ажил олгогчид нэг удаагийн санхүүгийн дэмжлэг;

12.6.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэлж байгаа бизнес, тэдний үүсгэл, санаачилгаар байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн болон хууль тогтоомжид заасан бусад дэмжлэг;

12.6.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцсон мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг;

12.6.6.мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал;

12.6.7.хууль тогтоомжид заасан бусад дэмжлэг.

12.7.Энэ хуулийн 12.6.2-т заасан шаардлагатай тохируулгын хэрэгцээг үнэлэх, тохируулга хийх үйлчилгээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

12.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнийг асарч байгаа хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа, ажил, үйлчилгээг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нөхцөлөөр давуу эрх олгоно.

12.9.Энэ хуулийн 12.6-д заасан дэмжлэгийн хөтөлбөр, төсвийн хуваарь, дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан эрх бүхий этгээд батална.

12.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээд татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлнэ.

12.11.Цалин хөлс авч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглоно.

13 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэний хэрэгжүүлэх арга хэмжээ

13.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр иргэн, хуулийн этгээд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

13.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах;

13.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллахад аливаа хэлбэрийн саад бэрхшээлгүй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, шаардлагатай тохируулгаар хангах;

13.1.3.байгууллагын дотоод хэм хэмжээний баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгааллыг сайжруулах зохицуулалтыг тусган хэрэгжүүлэх;

13.1.4.ажилтны хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

13.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах, цалин хөлс авах, албан тушаал дэвшихэд нь дэмжих;

13.1.6.ажлын байрны сонгон шалгаруулалтын зар, мэдээлэл, бүртгэл, шалгалт, ярилцлага болон бусад үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн хүртээмжтэй нөхцөл, харилцааны дэмжлэг, нэмэлт цаг болон шаардлагатай бусад тохируулгаар хангах;

13.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн, иргэн, байгууллагын гаргасан санаачилгыг дэмжих.

13.2.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт тавьж, мөн хуулийн 144.3-т заасан төлбөрийг бүрдүүлж, уг хуульд заасан дэд санд төвлөрүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХ

14 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх

14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бусадтай адил тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтгүйгээр авах эрхтэй.

14.2.Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ түүний хүсэл зориг, мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах эрх, хувийн нууц, халдашгүй байдлыг хүндэтгэх бөгөөд аливаа хүчирхийллийн арга хэлбэр хэрэглэхийг хориглоно.

15 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

15.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах чиглэлээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохируулга, орчин нөхцөлийг бүрдүүлэх, шинэчлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх зардлыг төсөвт тусгуулах, хэрэгжүүлэх, эмч, мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх;

15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тогтвортой байдлыг хангах, амь насыг хамгаалах зайлшгүй шаардлагаар тасралтгүй, байнга хэрэглэдэг эм, эмийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хүртээмжтэй түгээх нэгдсэн бодлогоор хангах;

15.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болон эрэлттэй мэргэжлийн хүний нөөцийн судалгаа гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр хүргүүлэх;

15.1.4.бие махбод, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн алдагдал, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх, хяналт тавих.

15.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.2.1.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх;

15.2.2.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн, шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин бүрдүүлэх;

15.2.3.төрөөс эрүүл мэндийг дэмжих, хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах, хөнгөвчлөх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

15.2.4.бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд бэлгийн болон нөхөн үржихүйтэй холбоотой эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхдээ мэдээллээр хангаж, түүний зөвшөөрлийг үндэслэх;

15.2.5.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;

15.2.6.хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүнийг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах.

15.3.Шаардлагатай тохируулга бүхий, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, энэ хуулийн 15.2.3-т заасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

15.4.Энэ хуулийн 15.2.6-д заасан үйлчилгээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ, БИЕ ДААН АМЬДРАХ

16 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээ

16.1.Хөгжлийн бэрхшээлийн улмаас үйлдэл, үйл ажиллагаа алдагдсан, хязгаарлагдсан хүний бие махбод, оюун санаа, нийгмийн, мэргэжлийн чадварыг боломжит дээд түвшинд нөхөн сэргээх зорилгоор сэргээн засах болон амьдралын чадварт бэлтгэх цогц арга хэмжээг амьдарч буй орчинд, хамт олонд нь ойр байдлаар хэрэгжүүлнэ.

16.2.Нөхөн сэргээх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

16.2.1.өвчин эмгэг, биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүсэх үр дагаврыг арилгахад чиглэсэн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал, бариа засал, сувилах зэрэг эрүүл мэндийн;

16.2.2.нас, хөгжлийн онцлогт тохируулан суурь мэдлэг, чадвар, төлөвшил олгох боловсролын;

16.2.3.хөдөлмөр эрхлэх ур чадварт бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн дадал эзэмшүүлэх хөдөлмөрийн;

16.2.4.өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх дадал, чадвар олгох, өөртөө үйлчлэх, нийгэмших, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нийгмийн.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан үйлчилгээг нас, хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан танхимын болон явуулын хэлбэрээр, цагаар болон өдрөөр үзүүлж болно.

16.4.Нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх тохируулга бүхий орчныг бүрдүүлсэн байх бөгөөд мэргэжлийн эмч, багш, сэргээн засахын мэргэжилтэн, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг мэргэжлийн хүний нөөцтэй байна.

16.5.Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энэ хуулийн 29.2.1-д заасан хүүхдийн зөвлөл энэ хуулийн 18.17-д заасан аргачлалын дагуу, 18 ба түүнээс дээш насны хүнийг энэ хуулийн 29.6-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөл энэ хуулийн 29.7-д заасан аргачлалын дагуу тус тус үнэлнэ.

16.6.Энэ хуулийн 16.2-т заасан үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлж болно.

16.7.Нөхөн сэргээх үйлчилгээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

16.8.Байнгын асаргаа шаардлагатай, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй нь энэ хуулийн 29.2.1-д заасан хүүхдийн зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энэ хуулийн 35.2-т заасан хөгжлийн төв, эсхүл энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээс хөгжлийг нь дэмжих үйлчилгээг танхимын болон явуулын хэлбэрээр, өдрөөр болон цагаар авах эрхтэй.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үйлчилгээний аргачлал, зааврыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, жишиг үнийг тус байгууллагын дарга санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн батална. Үйлчилгээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болох бөгөөд үйлчилгээний зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

16.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

17 дугаар зүйл.Туслах хэрэглэгдэхүүн

17.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энэ хуулийн 29.2.1-д заасан хүүхдийн зөвлөлийн, 18 ба түүнээс дээш насны хүнийг энэ хуулийн 29.6-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөлийн дүгнэлтийг тус тус үндэслэн туслах хэрэглэгдэхүүний хөнгөлөлтөд хамруулна.

17.2.Туслах хэрэглэгдэхүүний жагсаалт, түүнд тавигдах шаардлага, жишиг үнийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалтад үндэслэн Засгийн газар батална.

17.3.Туслах хэрэглэгдэхүүний зардлыг Нийгмийн халамжийн сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тухай хуульд заасны дагуу тус тус санхүүжүүлнэ.

17.4.Туслах хэрэглэгдэхүүнийг гадаад улсад хийлгэсэн, эсхүл худалдан авсан бол түүний зардлын төлбөрийг энэ хуулийн 17.2-т заасны дагуу баталсан жагсаалт, жишиг үнийг баримтлан нөхөн олгоно.

17.5.Туслах хэрэглэгдэхүүний хэрэгцээ, шаардлага, өртөг, шинэ дэвшилтэт технологи, хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, программ хангамжийн талаарх судалгааг 3 жил тутам хийж, уг судалгаанд үндэслэн энэ хуулийн 17.2-т заасан жагсаалт, шаардлага, жишиг үнийг шинэчилнэ.

17.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүн, туслах хэрэглэгдэхүүн нь хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд таарахгүй болсон болон эдэлгээний хугацаа дууссан тохиолдолд зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлнэ.

17.7.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу протез, ортопедийн зардлын төлбөрийг авах эрх үүсэзгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан өндөр болон зарим дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэглэгдэхүүн, туслах хэрэглэгдэхүүний үнийн хөнгөлөлт, түрээсийн төлбөрийн зарим хэсгийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу хэсэгчлэн санхүүжүүлнэ.

17.8.Эмнэлгийн хэрэглэгдэхүүнээс бусад туслах хэрэглэгдэхүүний үнийн хөнгөлөлтийн зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж, тус байгууллага Засгийн газраас баталсан жагсаалт, олгох давтамж, жишиг үнийг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нөхөн олгоно.

17.9.Энэ хуулийн 17.6, 17.7-д заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр Нийгмийн халамжийн сангаас Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлнэ.

17.10.Энэ хуулийн 17.6, 17.7-д заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр үйлчлэх, олгох журмыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батална.

17.11.Энэ хуулийн 17.8-д заасан туслах хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, түрээслэх, олгох, тохируулах, сургалт, зөвлөгөө өгөх журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах үйлчилгээ, санхүүжилт

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил нийгэм, хамт олон дотроо хараат бус, бие даан амьдрах, оршин суух газраа, хаана, хэнтэй амьдрахаа чөлөөтэй сонгох эрхтэй.

18.2.Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна:
- 18.2.1.хувийн туслахын үйлчилгээ;
- 18.2.2.дэмжих бүлэг буюу харилцан суралцах үйлчилгээ;
- 18.2.3.бие даан амьдрахад бэлтгэх түр байрлуулах үйлчилгээ;
- 18.2.4.дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ;
- 18.2.5.хөтөч нохойн үйлчилгээ.

18.3.Энэ хуулийн 18.2.1-д заасан үйлчилгээ дараах хэлбэртэй байна:
- 18.3.1.гэрийн орчинд үзүүлэх;
- 18.3.2.олон нийтийн орчинд дагалдах;
- 18.3.3.сургалт, ажил хөдөлмөрт дэмжлэг үзүүлэх.

18.4.Хувийн туслах нь үйлчлүүлэгчийн хэрэгцээг хүндэтгэх, нууцлалыг хадгалах, ёс зүйг баримтлах, аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй.

18.5.Энэ хуулийн 18.2.2-т заасан үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүн болон тэдний гэр бүл, асран хамгаалагчид өөрсдийн туршлага, мэдээлэл, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгийг харилцан солилцох, бие биедээ туслах зорилгоор зохион байгуулдаг үйл ажиллагааг хэлнэ.

18.6.Энэ хуулийн 18.2.2-т заасан үйлчилгээ дараах хэлбэртэй байна:

18.6.1.сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;

18.6.2.туршлага хуваалцах;

18.6.3.сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх.

18.7.Энэ хуулийн 18.2.3-т заасан үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад шилжихэд дэмжих, бэлтгэх зорилгоор аюулгүй, хүртээмжтэй түр орон байраар хангах, өдөр тутмын амьдралын ур чадвар эзэмшихэд чиглэсэн дэмжлэгийг хэлнэ.

18.8.Энэ хуулийн 18.2.3-т заасан үйлчилгээ нь хүний эрхэд суурилсан, сонголт, бие даасан байдлыг хүндэтгэсэн, аюулгүй байдал, хүртээмжийг хангасан нийгэмд суурилсан түр амьдрах төвийн хэлбэртэй байна.

18.9.Энэ хуулийн 18.2.4-т заасан үйлчилгээг тухайлсан хуулиар зохицуулна.

18.10.Хөтөч нохойн үйлчилгээг тусгай сургалтад хамрагдсан нохойгоор үзүүлнэ. Хөтөч нохойтой хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн зориулалттай барилга байгууламж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, үйлчилгээний газарт саадгүй нэвтрэх эрхтэй бөгөөд эдгээрийн эзэмшигч, удирдлага түүнийг нэвтрүүлэх үүрэгтэй. Хөтөч нохойг сургах, нийтийн орчинд нэвтрүүлэх журам, стандартыг Засгийн газар батална.

18.11.Энэ хуулийн 18.2.1, 18.2.2-т заасан үйлчилгээ болон 18.2.3-т заасан төвөөр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний хоол хүнс, хувцас, эм, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэгдэхүүний зардлыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.5-д заасан журмыг үндэслэн Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

18.12.Энэ хуулийн 18.2.3-т заасан үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон байраар хангах зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

18.13.Хувийн туслах, хөтөч бэлтгэх сургалтын болон олон нийтэд таниулах нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

18.14.Хөтөч нохой сургахтай холбоотой зардлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

18.15.Энэ хуулийн 18.2.4-т заасан үйлчилгээг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлсэн байгууллага дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний төлбөрийг хэлмэрч, орчуулагч, эсхүл түүний ажилладаг байгууллагад төлнө.

18.16.Энэ хуулийн 18.2.1-д заасан үйлчилгээ авах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлчилгээний төлбөрийн 10 хүртэл хувийг хариуцна.

18.17.Энэ хуулийн 16.8, 18.20, 29.7-д зааснаас бусад нөхөн сэргээх, бие даан амьдрах үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үнэлэх аргачлал, үйлчилгээний жишиг үнэ, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулах, энэ хуулийн 16.2, 18.2-т заасан үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг тус тус Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

18.18.Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний төлөөллийн байгууллагатай зөвшилцөн байгууллагад суурилсан асрамж, тусгаарласан орчинд байршуулах хэлбэрийг үе шаттай бууруулах, шаардлагатай дэмжлэгээр хангах замаар бие даан амьдрах, хамт олны дунд оролцох нөхцөлийг бүрдүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.

18.19.Энэ хуулийн 18.3.1-д заасан хувийн туслахын үйлчилгээний зардлыг Нийгмийн халамжийн сангаас, 18.3.2-т заасныг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсвөөс, 18.3.3-т заасныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус тус санхүүжүүлнэ.

18.20.Энэ хуулийн 19.1.3-т заасан үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 18.3.2-т заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн тус тус батална. Энэ хуулийн 18.3.3-т заасан үйлчилгээний журмыг Үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан эрх бүхий этгээд батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХ

19 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн үйлчилгээ, санхүүжилт

19.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд Нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хөнгөлөлтийг үзүүлнэ:

19.1.1.Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийг;

19.1.2.Нийгмийн халамжийн тухай хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ;

19.1.3.энэ хуулийн 29.2.1, 29.6-д заасан зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн энэ хуулийн 18.3.1-д заасан хувийн туслахын үйлчилгээ, урт хугацааны сэргээн засах үйлчилгээ, өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ, асран хамгаалагчийг түр орлон асрах үйлчилгээ;

19.1.4.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн суралцахуйн төв, хүүхэд харах, хөгжүүлэх төвийн үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд унааны зардлыг жилд нэг удаа;

19.1.5.орон нутгаас албан боловсрол эзэмших зорилгоор аймаг, нийслэлд ирж сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирэх, буцах унааны зардлыг жилд нэг удаа;

19.1.6.нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн тухайн орон нутагтаа эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, шинжилгээ хийх боломжгүй болохыг аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын зөвлөлөөс тодорхойлсон шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх

тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнийг дагалдан яваа нэг асран хамгаалагч, харгалзан дэмжигчид унааны зардлыг жилд нэг удаа 100 хувь;

19.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувь;

19.1.8.магадлан итгэмжлэгдсэн сувилалд сувилуулах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь, түүнийг асран халамжилж яваа нэг хүнд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд 50 хувиар сувиллын эрхийн бичгийн үнийг жишиг үнийн дагуу тооцон жилд нэг удаа;

19.1.9.аарцаг эрхтний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай тохиолдолд живхний үнийн хөнгөлөлт;

19.1.10.бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон бол ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа;

19.1.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 100 хувийг жилд нэг удаа;

19.1.12.нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж;

19.1.13.байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, харах, ярих, сонсох чадвараа бүрэн алдсан болон одой хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн түрээсийн орон сууцанд амьдардаг бол түрээсийн төлбөрийн зөрүү, төвлөрсөн инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд амьдардаг бол орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь Нийгмийн халамжийн тухай хуульд заасан орон сууцны хөлс, түлшний дэмжлэгтэй давхардуулахгүйгээр жилд нэг удаа мөнгөн тусламж;

19.1.14.18 ба түүнээс дээш насны харах, ярих, сонсох чадвараа бүрэн алдсан байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт сар бүр.

19.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн таксинаас бусад нийтийн тээврийн хэрэгслээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино.

19.3.Энэ хуулийн 19.2-т заасан үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

19.4.Энэ хуулийн 19.1-д заасан Нийгмийн халамжийн сангаас олгох тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, дээд хязгаар, хамрагдах хүнд тавих нөхцөл, шалгуур, олгох журам, энэ хуулийн 19.2-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар тус тус батална.

19.5.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд тохируулан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу ялгаатай тогтоож болно.

19.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэврээс бусад тэтгэмж, үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт үргэлжлүүлэн хамрагдана.

20 дугаар зүйл.Нийгмийн даатгалын үйлчилгээ, санхүүжилт

20.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлийн гишүүнд нийгмийн даатгалын сангаас доор дурдсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг олгоно:

20.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3.1.2-т заасан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг өөрт нь;

20.1.2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4.1.1-д заасан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 4.1.5-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөр, 4.1.7-д заасан эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг өөрт нь;

20.1.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3.1.3-т, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4.1.2-т заасан тэжээгчээ алдсаны тэтгэвэр, мөн хуулийн 4.1.4-т заасан тэтгэмжийг гэр бүлийн гишүүнд.

21 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

21.1.Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн байгууллага нь дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

21.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, дэмжлэг олгох;

21.1.2.үйлчилгээ үзүүлэх байгууллагын байр, дэд бүтэц, мэдээллийн технологийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцүүлэн тоноглох;

21.1.3.нийгмийн хамгааллын үйлчилгээ болон эрх зүйн туслалцааны талаарх мэдээлэл, зөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүнд дохионы хэл, брайль үсэг болон хялбаршуулсан хэлбэрээр хүргэх;

21.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа гэр бүлийн гишүүний асаргааны ачааллыг үнэлж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, асаргааны арга барилд сургах, түр орлон асрах үйлчилгээнд холбон зуучлах.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БУСАД ЭРХ

22 дугаар зүйл.Орон байраар хангах, дэмжих үйлчилгээ

22.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангах, орон байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрны нөхцөл байдал, хэрэгцээний судалгаа хийж, орлогод нийцсэн халамжийн, түрээсийн, амины орон сууцны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх;

22.1.2.төрийн өмчийн орон сууцны 10-аас доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулах;

22.1.3.ипотекийн зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дараалал харгалзахгүй хамруулах;

22.1.4.ипотекийн зээлд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүний урьдчилгаа төлбөрт батлан даалтын сангаас дэмжлэг үзүүлэх.

22.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангах, орон байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.2.1.халамжийн, түрээсийн, амины орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулахад шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгах бөгөөд эдгээр арга хэмжээнд анх удаа гэр бүл болсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэргүүн ээлжид хамруулах;

22.2.2.гэр хороолол, хувийн орон сууцанд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрыг инженерийн дэд бүтцэд холбох болон тохируулгаар хангах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх;

22.2.3.энэ хуулийн 22.2.1, 22.2.2-т заасан арга хэмжээнд хамрагдах хүний хүсэлтийг хүлээн авч бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх.

22.3.Гэрч, хохирогчийг хамгаалах байр, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй байна.

23 дугаар зүйл.Онцгой байдлын үед авах арга хэмжээ

23.1.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал, цар тахал зэрэг онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

23.1.1.онцгой байдлын мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэйгээр хүргэх;

23.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг тусгасан гамшгаас хамгаалах төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

23.1.3.байгалийн гамшиг, цар тахлын үеийн хөл хорио, нийтийг хамарсан үймээн самуун, бослого тэмцэл, ажил хаялт, бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран бүх цаг үе, нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэ хуулийн 18.2.1, 18.2.4-т заасан үйлчилгээг тасралтгүй авах боломжоор хангах;

23.1.4.гамшиг, онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэргүүн ээлжид нүүлгэн шилжүүлэх, хүртээмжтэй түр байранд байрлуулах, шаардлагатай эм, туслах хэрэглэгдэхүүн, асаргааны тасралтгүй байдлыг хангах;

23.1.5.аврах, хайх ажиллагаанд оролцох албан хаагчийг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах, туслах арга зүйд сургах;

23.1.6.гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийн байгууллагыг оролцуулах.

23.2.Сум, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийг мэдээллийн нэгдсэн сангаас авч, гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тэдгээр хүнийг нүүлгэн шилжүүлэх, мэдээлэл хүргэх арга хэмжээг тусгана.

23.3.Энэ хуулийн 23.1.2, 23.2-т заасан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

24 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх

24.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.4-т заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцааг онцлог хэрэгцээндээ нийцсэн хэлбэрээр үнэ төлбөргүй авах эрхтэй.

24.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд, түүний дотор сэтгэц, оюун санааны хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад харилцаанд эрх зүйн үр дагавар бүхий сонголт хийж, шийдвэр гаргахад нь түүний хэрэгцээг үнэлж, хүсэл зоригийг хүндэтгэн дэмжлэг үзүүлнэ.

24.3.Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь харьяа байгууллагынхаа барилга байгууламж, цахим систем, мэдээлэл, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй болгох үе шаттай төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.

24.4.Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид эрх зүйн боловсрол олгох, хууль зүйн зөвлөгөөг тэдний бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр хүргэх бөгөөд энэхүү үйл ажиллагааг хүн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

24.5.Энэ хуулийн 24.3-т заасан байгууллага текст уншигч, бичигч төхөөрөмж, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ болон энэ хуулийн 24.3-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж, тоног төхөөрөмжийг нэгдсэн журмаар хангана.

24.6.Энэ хуулийн 24.2, 24.4-т заасан үйлчилгээг үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах, үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих журам, жишиг үнийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.7.Энэ хуулийн 24.2-т заасан дэмжлэг нь тухайн хүний эрх, нэр төр, хүсэл зориг, давуу сонголтыг хүндэтгэх, ашиг сонирхлын зөрчил, дарамт, хууран мэхлэлт, зүй бус нөлөөллөөс ангид байх бөгөөд дэмжлэг үзүүлэгч нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүний өмнөөс шийдвэр гаргах, хэлцэл хийх, эрхээс татгалзах, эд хөрөнгө болон санхүүгийн эрхийг хязгаарлахгүй.

24.8.Хүнийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан эрх зүйн чадамжгүйд тооцож орлон шийдвэр гаргах тогтолцооноос дэмжлэгтэй шийдвэр гаргах тогтолцоонд үе шаттай шилжих төлөвлөгөөг Засгийн газар баталж хэрэгжүүлнэ.

24.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

24.10.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлсэн баримт бичиг, харилцааны туслах хэрэгсэл болон процессын бусад тохируулгаар үнэ төлбөргүй хангана. Процессын тохируулга хийх журмыг холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар зохицуулна.

25 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог хангах

25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Монгол Улсын Үндсэн хууль, сонгуулийн хууль тогтоомжийн дагуу бүх шатны сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй.

25.2.Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч бүх шатны сонгуульд саналаа өөрөө, эсхүл өөрийн сонгосон хүний туслалцаатайгаар өгөх эрхтэй.

25.3.Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн онцлог хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй байна.

25.4.Улс төрийн нам, эвсэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь дэмжих үүрэгтэй.

25.5.Улс төрийн нам, эвсэл, бие даагч нь бодлого, мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг тусгана.

25.6.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй сонгогч бие даан, чөлөөтэй, нууцаар саналаа өгөх орчин, нөхцөл бүрдсэн байна.

25.7.Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн санал өгөх орчин, нөхцөлийг бүрдүүлэх ажлыг тухайн шатны Засаг дарга сонгуулийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

26 дугаар зүйл.Хувийн нууцыг хүндэтгэх

26.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эмзэг, хувийн, хөрөнгийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

26.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн мэдээллийг задруулахыг хориглоно.

27 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих

27.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Биеийн тамир, спортын тухай хууль болон олон улсын спортын байгууллагын ангилал, дүрэм, стандартад заасныг баримтлан биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулна.

27.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

27.2.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тэмцээн, уралдаан зохион байгуулах, оролцуулах, идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэхэд нь дэмжлэг үзүүлэх;

27.2.2.бүх шатны биеийн тамир, спортын байгууллага нь барилга байгууламж, мэдээлэл харилцаа, үйлчилгээний хүртээмжтэй орчин, нөхцөл, шаардлагатай тохируулгыг бүрдүүлсэн байх;

27.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

27.2.4.паралимп, дифлимп, тусгай олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, 18 ба түүнээс дээш насны тамирчны хувийн туслах, 18 хүртэлх насны тамирчны хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, дохионы хэлний хэлмэрчид шаардагдах зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлэх;

27.2.5.паралимп, дифлимп, тусгай олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож,

медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний дасгалжуулагчид Биеийн тамир, спортын тухай хуулийн 9.1.1-д заасан журмын дагуу мөнгөн шагнал олгох;

27.2.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нас, биеийн онцлогт нь тохирсон идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

27.3.Энэ хуулийн 27.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт жил бүр тусгана.

27.4.Энэ хуулийн 27.2.4, 27.2.5-д заасан арга хэмжээг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

27.5.Паралимп, дифлимп, тусгай олимп, тив болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцож, медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувийг тухайн тэмцээн зохион байгуулагдах давтамжийн хугацааны сарын тоогоор үржүүлж тооцсон мөнгөн урамшууллыг тухайн тэмцээний төрөлд нэг удаа олгоно.

27.6.Энэ хуулийн 27.5-д заасан мөнгөн урамшуулалд шаардагдах төсвийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусгана.

27.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

28 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих

28.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, урлагийн талаар Соёлын тухай хуулийн 14.1-д заасан эрхийг эдэлнэ.

28.2.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгана:

28.2.1.хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, хөгжлийн бэрхшээлийн талаар ээрэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;

28.2.2.бүх шатны соёл, урлагийн байгууллага нь барилга байгууламж, мэдээлэл харилцаа, үйлчилгээний хүртээмжтэй орчин, нөхцөл, шаардлагатай тохируулгыг бүрдүүлсэн байх;

28.2.3.бүс, тив, дэлхийн чанартай тэмцээн, уралдаанд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцож, медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд Засгийн газраас баталсан журамд заасан урамшууллыг 1.5 дахин нэмэгдүүлэн олгох;

28.2.4.соёл, урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.2.5.соёл, урлагийн чиглэлээр хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэг удаа шаардлагатай багаж, техник, хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

28.2.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гутаан доромжилсон, үзэн ядалтыг өдөөсөн агуулгатай соёл, урлагийн арга хэмжээ, уран бүтээлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах.

28.3.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн уран бүтээлээ олон нийтэд толилуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд байр, талбайн түрээсийн төлбөрөөс 50 хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

28.4.Өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагын барилга, байгууламж, үзвэр үйлчилгээ нь шаардлагатай тохируулга бүхий, саадгүй, хүртээмжтэй байна.

28.5.Соёл, урлагийн байгууллага энэ хуулийн 28.4-т заасан тохируулгыг үе шаттай хийх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, зардлыг төсөвтөө тусгана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХИЙГ ТОГТООХ, БҮРТГЭХ

29 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох

29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах шалгууруар тогтооно:

29.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа;

29.1.2.үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал.

29.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах зөвлөл тогтооно:

29.2.1.18 хүртэлх насны хүүхдийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл (цаашид “хүүхдийн зөвлөл” гэх);

29.2.2.18 ба түүнээс дээш насны хүнийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл.

29.3.Энэ хуулийн 29.2.1-д заасан хүүхдийн зөвлөл нь энэ хуулийн 35.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв зөвлөл (цаашид “төв зөвлөл” гэх), аймаг, дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон тооны бус салбар зөвлөл (цаашид “хүүхдийн салбар зөвлөл” гэх)-тэй байна. Хүн амын нягтрал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог харгалзан сум, тосгонд хүүхдийн салбар зөвлөл ажиллуулж болно.

29.4.Энэ хуулийн 29.2.2-т заасан эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу ажиллана.

29.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний дэмжлэг, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлохдоо хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүндрэлийн түвшнээс гадна өдөр тутмын үйл ажиллагаа, бие даан амьдрах боломж, амьдрах орчны нөхцөлийг харгалзана.

29.6.18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллах мэргэжлийн хамтарсан зөвлөл хийж, туслах хэрэглэгдэхүүн, хувийн туслах, урт хугацааны сэргээн засах болон асаргааны хувилбарт үйлчилгээний хэрэгцээг тодорхойлно.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасан бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээний шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх аргачлалыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

29.8.Энэ хуулийн 29.6-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн хувийн цогц төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсрол, сэргээн засах болон нийгмийн оролцоог дэмжих чадваржуулах үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээ, хувийн туслахын үйлчилгээ, урт хугацааны сэргээн засах үйлчилгээ, шаардлагатай тохируулга, туслах хэрэглэгдэхүүний дэмжлэгт холбон зуучилж, хэрэгжилтэд хяналт тавина.

30 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл

30.1.Хүүхдийн зөвлөл нь 18 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах, зөвлөгөө, мэдээллээр хангах, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

30.2.Төв зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал хариуцсан албан хаагчтай байна.

30.3.Энэ хуулийн 29.1.2-т заасан ангиллыг ашиглан хөгжлийн бэрхшээлийг тогтоох өвчин, гэмтлийн жагсаалт гаргах, хөгжлийн бэрхшээлийг тогтооход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн хороог төв зөвлөлийн дэргэд ажиллуулж болно.

30.4.Энэ хуулийн 30.3-т заасан мэргэжлийн хороо нь эрүүл мэнд, боловсролын салбарыг төлөөлсөн тус бүр 2, эрдэмтэн, судлаач 3, нийт 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

30.5.Хүүхдийн салбар зөвлөл нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй аймаг, дүүрэгт 9 гишүүнтэй байж болно.

30.6.Хүүхдийн салбар зөвлөлийн дарга нь аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого, хөгжлийн асуудал хариуцсан газар (хэлтэс)-ын дарга, гишүүн нь хүүхэд, мэдрэл, сэтгэц, эсхүл сэргээн засахын эмч 2, боловсролын байгууллагын тэргүүлэх хамруулах боловсрол болон хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан 1, хүүхэд, гэр бүлийн байгууллагын зорилтот бүлгийн хүүхдийн асуудал хариуцсан 1 албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын 1 орон тооны бус гишүүн байна.

30.7.Хүүхдийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг тухайн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт, хэрэв аймаг, дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй бол уг төвд орон тоогоор ажиллуулна.

30.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй аймаг, дүүрэгт энэ хуулийн 30.6-д зааснаас гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөлөл 1 гишүүнийг нэмж ажиллуулна.

30.9.Хүүхдийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлыг сард 1-ээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд хурал танхим, цахим, явуулын хэлбэртэй байна.

30.10.Гамшиг, аюулт үзэгдэл, осол, халдварт өвчний тархалтын үед, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал, онцгой байдал зарласан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалтай холбоотой яаралтай хэлэлцэх шаардлагатай асуудал үүссэн тохиолдолд хүүхдийн салбар зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр хуралдуулж болно.

30.11.Эрүүл мэндийн шалтгаанаар, эсхүл гадаад улсад амьдарч, эмчлүүлж байгаа шалтгаанаар хүүхэд салбар зөвлөлийн хуралд биечлэн оролцох боломжгүй талаар хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан тохиолдолд хүүхдийн эмчлүүлж байгаа талаарх тухайн улсын эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, оношилгоо, шинжилгээ, дүгнэлт, зураг, видео бичлэгт үндэслэн цахим уулзалтыг ашиглан хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоох, шийдвэрийн хугацааг сунгах асуудлыг хүүхдийн салбар зөвлөл хэлэлцэн, шийдвэрлэж болно.

30.12.Хүүхдийн зөвлөл нь эрх, үүргийн хүрээнд дүгнэлт, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар гаргана.

30.13.Энэ хуулийн 30.4, 30.6, 30.8-д заасан гишүүнд хуралдсан цагаар нь тооцож улирал бүр урамшуулал олгоно.

30.14.Төв зөвлөлийн үйл ажиллагааны болон энэ хуулийн 30.13-т заасан гишүүний урамшууллын зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсвийн багцад жил бүр тусган, санхүүжүүлнэ.

30.15.Хүүхдийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Засаг дарга орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

30.16.Хүүхдийн зөвлөлийн ажиллах дүрэм, энэ хуулийн 30.13-т заасан цагийн урамшууллын хэмжээг Засгийн газар батална.

30.17.Энэ хуулийн 30.4-т заасан мэргэжлийн хорооны ажиллах журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

30.18.Хүүхдийн салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төв зөвлөлд гомдол гаргана. Төв зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

30.19.Төв зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

31 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн нэгдсэн сан

31.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, авч буй үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт болон холбогдох бусад мэдээллийг агуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх)-тай байна. Мэдээллийн нэгдсэн санг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрсөн маягт, нөхөх зааврын дагуу хөтөлнө.

31.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 31.1-д заасан сангийн мэдээллийг судалгаа, шинжилгээ, үнэлгээ,

хэтийн тооцоолол, бодлого боловсруулах, хяналт шалгалт хийх, захиргааны статистикийн мэдээ, тайлан гаргах, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх зорилгоор ашиглана.

31.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх зорилгоор төрийн бусад байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглана.

31.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг Үндэсний статистикийн хорооны саналыг авч, Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

31.5.Мэдээллийн нэгдсэн санг дараах байдлаар бүрдүүлнэ:

31.5.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэний иргэний бүртгэлийн мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас;

31.5.2.18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, байнгын асаргаа зэрэг мэдээллийг энэ хуулийн 29.2.1-д заасан зөвлөлөөс;

31.5.3.18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийг Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн сангаас;

31.5.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний авч буй тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн дэмжлэг, үйлчилгээний мэдээллийг Нийгмийн даатгалын байгууллага болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын мэдээллийн сангаас;

31.5.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх, эрхийг хангах, хамгаалах чиглэлээр шаардлагатай мэдээллийг төрийн бусад байгууллагаас.

31.6.Үйлчилгээг цахимжуулах, бүртгэлийн давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүн болон түүний асран хамгаалагчийн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.

31.7.Энэ хуулийн 29.2-т заасан зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэж, үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ. Үнэмлэхийг цаасан болон цахим хэлбэрээр олгоно.

31.8.Энэ хуулийн 31.7-д заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болох бөгөөд цахим үнэмлэх нь цаасан үнэмлэхтэй адил хүчинтэй байна.

31.9.Үнэмлэхийн загвар, түүнийг цаасан болон цахим хэлбэрээр олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

АРАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

32 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

32.1.Монгол Улсын Их Хурал хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.төрөөс баримтлах хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах бодлогыг тодорхойлох;

32.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих, шаардлагатай төсвийг батлах;

32.1.3.хууль тогтоомжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн мэдрэмжтэй боловсруулсан эсэхэд хяналт тавьж батлах;

32.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтийн тайланг 2 жил тутам чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тогтоол гаргах;

32.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

33 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

33.1.Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах талаар баримтлах бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн тусгаж хэрэгжүүлэх;

33.1.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

33.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомж, конвенц, холбогдох байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, Засгийн газрын гишүүдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2 жил тутам хэлэлцэх;

33.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, өөрийн бүрэн эрхийн хүрээнд гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

33.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд тайлагнах;

33.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангахад чиглэсэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

33.1.7.хөгжлийн бэрхшээлийн нөхцөл байдлыг судлах, үнэлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

33.1.8.харьяа байгууллагын болон салбар дундын хүний нөөцийг тасралтгүй сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

33.1.9.хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан байгууллагын орон тооны нормативыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн батлах;

33.1.10.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтны нийгмийн баталгааг хангах бодлого хэрэгжүүлэх;

33.1.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

33.2.Засгийн газрын гишүүн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.2.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн зардлыг Төсвийн тухай хуульд заасан төсвийн

нэгдсэн ангиллын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр тусгайлан бүртгэж, тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх;

33.2.2.Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх;

33.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгах, зарцуулалтыг олон нийтэд тайлагнах;

33.2.4.салбарын бодлого, хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллыг сайжруулах, оролцоог хангах асуудлыг тусган хэрэгжүүлэх;

33.2.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

33.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарна.

34 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэн эрх

34.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, байцаагч, ажилтнаас бүрдэнэ.

34.2.Үндэсний зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байна.

34.3.Монгол Улсын Ерөнхий сайд Үндэсний зөвлөлийг тэргүүлж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана.

34.4.Үндэсний зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллагад Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл /цаашид “дэд зөвлөл” гэх/, аймаг, нийслэл, дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл /цаашид “салбар зөвлөл” гэх/-тэй байна.

34.5.Үндэсний зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүнтэй байна. Дэд зөвлөлийн дарга төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн дарга аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байна.

34.6.Үндэсний зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.6.1.салбар дундын бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

34.6.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

34.6.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсвийн зарцуулалт болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

34.6.4.зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр сард багтаан баталж, дэд болон салбар зөвлөлд хүргүүлж, хэрэгжилтийг хангах;

34.6.5.дэд, салбар зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэх, үйл ажиллагааны нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, дүгнэлт, зөвлөмж, албан даалгавар өгөх, хэрэгжилтийг хангуулах;

34.6.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж, Засгийн газарт танилцуулах;

34.6.7.Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд тогтоол гаргах, хууль тогтоомжид заасан дүрэм, журам, аргачлалын төсөлд санал өгөх, зөвлөмж гаргах;

34.6.8.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үр бүтээлтэй ажилласан хүн, хуулийн этгээдийг шагнал, урамшилд тодорхойлох.

34.7.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын төлөөлөл 20-иос доошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл 9-өөс доошгүй, дэд болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын төлөөлөл 8-аас доошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл 5-аас доошгүй гишүүнтэй байна.

34.8.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах төрийн бус байгууллагын төлөөллийг энэ хуулийн 34.18-д заасан журмын дагуу Үндэсний зөвлөлийн Ажлын алба нээлттэй сонгон шалгаруулж, сонгогдсон нэр дэвшигчийн мэдээллийг Засгийн газарт ирүүлнэ.

34.9.Засгийн газар энэ хуулийн 34.8-д заасан нэр дэвшигчийн талаар сонсгол хийж, түүнийг дөрвөн жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө.

34.10.Дэд болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах төрийн бус байгууллагын төлөөллийг энэ хуулийн 34.18-д заасан журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга дөрвөн жилийн хугацаагаар зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө.

34.11.Үндэсний зөвлөлийн дэд даргыг зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөн төрийн бус байгууллагын төлөөллөөс хоёр жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

34.12.Үндэсний, дэд, салбар зөвлөлийн гишүүн хуульд заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болохоос өмнө чөлөөлөгдөх тохиолдолд дараагийн гишүүнийг энэ хуулийн 34.8–34.10-т заасны дагуу сонгон шалгаруулж, чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар томилно.

34.13.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээ тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ихгүй байна.

34.14.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, энэ хуулийн 34.13-т заасан урамшууллын зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

34.15.Дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг төрийн захиргааны төв байгууллага, салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

34.16.Үндэсний, дэд, салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд жилд 2-оос доошгүй удаа хуралдана. Үндэсний зөвлөл ажлаа Засгийн газарт, дэд болон салбар зөвлөл ажлаа Үндэсний зөвлөлд тайлагнана.

34.17.Үндэсний зөвлөлийн Ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

34.18.Үндэсний, дэд, салбар зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 34.8-д заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

35 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага, чиг үүрэг

35.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

35.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, сэргээн засах, туслах технологи, сургалт, хөгжлийн төвтэй байна. Аймаг, нийслэл, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үе шаттай тусгаж байгуулна.

35.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар томилж, чөлөөлнө.

35.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болно.

35.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар энэ хуулийн 35.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилсон бол байгууллага дэд даргатай байна. Энэ тохиолдолд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг хамаарахгүй.

35.6.Энэ хуулийн 35.2-т заасан төвийн дарга, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын байцаагч, ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

35.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.7.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, чиглэл гаргах;

35.7.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

35.7.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бодлого боловсруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагад уламжлах, төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

35.7.4.төрийн захиргааны төв байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх;

35.7.5.энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг энэ хуулийн 40.1-д заасан хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх, хяналт тавих;

35.7.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

35.7.7.хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үйлчилгээ үзүүлэх зорилгоор хүний хувийн мэдээллийг ашиглах;

35.7.8.гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй, өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг түүний сэтгэл зүй, нас, бие, сэтгэхүйн онцлог хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн түвшинд хүртээмжтэй үзүүлэх;

35.7.9.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистик мэдээллээр хангах;

35.7.10.хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

35.7.11.өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргуулахаар эрх бүхий байгууллагад санал боловсруулж, уламжлах;

35.7.12.байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянаж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах;

35.7.13.хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг тасралтгүй сургах, мэргэшүүлэх;

35.7.14.хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах;

35.7.15.Үндэсний зөвлөлийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах;

35.7.16.төрийн байгууллагатай төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем, эсхүл төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцох;

35.7.17.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

36 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих байцаагч

36.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн улсын байцаагч /цаашид “байцаагч” гэх/-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

36.2.Аймаг, дүүрэгт 1-ээс доошгүй байцаагчтай байна.

36.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн улсын ерөнхий байцаагч /цаашид “Ерөнхий байцаагч” гэх/ байна.

36.4.Ерөнхий байцаагчийн эрхийг Ерөнхий сайд, байцаагчийн эрхийг Ерөнхий байцаагч тус тус олгож, цуцална.

36.5.Байцаагч нь хөгжлийн бэрхшээлийн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, дээд боловсрол эзэмшсэн, улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн байна.

36.6.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

36.7.Байцаагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг харьяа сум, дүүргийн холбогдох байгууллага, ажилтанд тавьж шийдвэрлүүлнэ.

36.8.Ерөнхий байцаагч, байцаагч нь Засгийн газраас баталсан үнэмлэх, тэмдэг, мэдэгдэл, албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

36.9.Байцаагчийн эрх олгох шалгалтын журам, байцаагчийн ажиллах дүрмийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална. Дүрэмд хөдөлмөрийн, боловсролын, барилгын хяналтын улсын байцаагчтай хамтран ажиллах, хяналт шалгалтыг давхардуулахгүй байх журмыг тусгана.

37 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын байцаагч, ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа

37.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байцаагч, ажилтан Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанаас гадна энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж, нийгмийн баталгаагаар хангагдана.

37.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн байгууллагын байцаагч, ажилтан дараах эрхтэй:

37.2.1.эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;

37.2.2.судалгаа шинжилгээний ажил хийх;

37.2.3.эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдах;

37.2.4.байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх болон шийдвэр гаргахад санал өгөх;

37.2.5.хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

37.2.6.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

37.2.7.мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах;

37.2.8.хуульд заасан бусад эрх.

37.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн байгууллагын байцаагч, ажилтан дараах үүрэгтэй:

37.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн, алдагдсан чадварыг нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээг чанартай хүргэх, хяналт тавих;

37.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

37.3.3.хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

37.3.4.төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх;

37.3.5.ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

37.3.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчих, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, удирдлага, ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;

37.3.7.байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, ажилтан, үйлчлүүлэгч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

37.3.8.улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

37.3.9.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

37.3.10.ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

37.3.11.хуульд заасан бусад үүрэг.

37.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн байгууллагын байцаагч, ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

37.4.1.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг нөхцөлийг харгалзан нэмэгдэл цалин, урамшуулал авах;

37.4.2.аймаг, алслагдсан дүүрэгт ажилладаг байцаагч, ажилтанд эхний тав дахь жилд болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж;

37.4.3.өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж;

37.4.4.амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцны дэмжлэг;

37.4.5.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн цалин хөлсийг нэмэгдүүлэх;

37.4.6.хуульд заасан бусад баталгаа.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан нийгмийн баталгааг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлан, шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн төсөвтөө тусган хэрэгжүүлнэ.

37.6.Энэ хуулийн 35.2-т заасан төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнд Эрүүл мэндийн тухай хуулийн 30.5-д заасан цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны нэгэн адил олгоно.

38 дугаар зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх, чиг үүрэг

38.1.Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсөв хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, биелэлтийг хангуулах;

38.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог дэмжих арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

38.1.3.барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

38.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даасан байдал, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

38.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх талаар иргэн, хуулийн этгээдийн санал, санаачилгыг дэмжих;

38.1.6.энэ хуулийн 19.2-т заасны дагуу нийтийн тээврийн хэрэгслээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчуулах, нөхөн олговрыг санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлэх, санхүүжилтийг жил бүрийн төсөвтөө тусган батлах;

38.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд зарцуулах хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангах;

38.1.8.энэ хуулийг сурталчлах, салбар зөвлөл, хүүхдийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

38.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

39 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг

39.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн, үр дүнтэй оролцохыг баталгаажуулах зорилгоор шаардлагатай тохируулгаар хангах, саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

39.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх;

39.1.2.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;

39.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний амжилт, бүтээлийг бусдын адил олон нийтэд сурталчлан таниулах;

39.1.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.9-д заасан ажил үүргээ гүйцэтгэх явцад хөгжлийн бэрхшээлтэй болсон ажилтанд тусламж, дэмжлэг үзүүлэх;

39.1.5.хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 39.1.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

39.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шаардлагатай тохируулгаар хангах, түүнийг зүй бус харьцаа, эрх, эрх чөлөөний зөрчил, ялгаварлал, бэлгийн болон бусад хэлбэрийн дарамт, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;

39.1.7.барилга байгууламж, мэдээлэл харилцаа, үйлчилгээний хүртээмжтэй орчин, нөхцөл, шаардлагатай тохируулгыг бүрдүүлсэн байх;

39.1.8.сонсголын бэрхшээлтэй хүн Монгол дохионы хэлээр харилцах нөхцөлийг бүрдүүлж, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээгээр хангах;

39.1.9.харааны бэрхшээлтэй хүн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг брайль бичиг, дуут, томруулсан үсэг, цахим хүртээмжтэй хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлэх;

39.1.10.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 144.8-д заасан нөхцөлийг бүрдүүлэх;

39.1.11.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

40 дүгээр зүйл.Төрийн чиг үүрэг, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага

40.1.Энэ хуульд заасан төрийн зарим чиг үүрэг, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хуулийн этгээд нь дүрмийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, магадлан итгэмжлэлтэй байна.

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан гүйцэтгэгчийг холбогдох хуульд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулж, үнэ, чанар, үйлчилгээний үр дүнгийн шалгууруар үнэлнэ. Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийн байгууллага бол давуу талд тооцно.

40.3.Гүйцэтгэгч гэрээний биелэлт, санхүүжилтийн зарцуулалтыг жил бүр нийтэд тайлагнана.

40.4.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн ажлыг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

41 дүгээр зүйл.Гомдол, нэхэмжлэл гаргах

41.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчийг асарч буй хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл зөрчлийг арилгуулахыг шаардах, харьяалан шийдвэрлэх эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол, хүсэлт гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд энэ эрхээ өөрөө, эсхүл хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ.

41.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага тухайн хүний бичгээр, эсхүл түүнд хүртээмжтэй хэлбэрээр өгсөн зөвшөөрөл, итгэмжлэлийн үндсэн дээр түүнийг төлөөлж, эсхүл хуульд заасан тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

42 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд энэ хууль, эсхүл Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.3.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан ялгаварлан гадуурхалт гаргасан нь тогтоогдсон хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх сургалтад хамруулна. Хуулийн этгээд зөрчил гаргасан бол эрх бүхий албан тушаалтныг нь сургалтад хамруулна.

42.4.Энэ хуулийн 42.3-т заасан сургалтын хөтөлбөр, зохион байгуулах журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.5.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол буруутай этгээдээр холбогдох хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

42.6.Иргэн, хуулийн этгээдийн мэргэжлийн болон ёс зүйн алдаатай аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгосон, эсхүл хөгжлийн бэрхшээлийг буруу тогтоосон, сэтгэл зүйн дарамтад оруулсан нь тогтоогдсон бол эрүүл мэндийг нөхөн сэргээхтэй холбоотой үүссэн зардал болон сэтгэл санааны хохирлыг барагдуулна.

42.7.Энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хүн, хуулийн этгээд, түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон холбогдох бусад сангаас дэмжлэг, санхүүжилт, хөнгөлөлт, нөхөн олговор авсан этгээд нь үйлчилгээ

үзүүлээгүй, дутуу, чанаргүй үзүүлсэн, хуурамч буюу зөрүүтэй баримт бүрдүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, хэмжээнээс илүүгээр зардлын төлбөр, санхүүжилт, дэмжлэг, нөхөн олговор, хөнгөлөлтийг тогтоолгон авсан нь хяналт шалгалтаар тогтоогдсон бол эрх бүхий байцаагчийн акт, эсхүл эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр илүү авсан хөрөнгийг холбогдох сан, улсын болон орон нутгийн төсөвт нөхөн төлүүлнэ.

43 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

43.1.Энэ хуулийг 2028 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

төсөл